



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 09 өдөр

Дугаар А/12

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгөөр Улаанбаатар хотын нийтийн тээврийн шинэчлэлтийн ажлын хүрээнд худалдан авсан 400 автобуснаас Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч “Эрдэм Транс” ХХК-тай хэлцлийн дагуу шилжүүлсэн 30 автобусны өр төлбөр болон гэрээний торгуулийн үлдэгдэл төлбөр болох нийт 2,143,165,833 (хоёр тэрбум нэг зуун дөчин гурван сая зуун жаран таван мянга найман зуун гучин гурав) төгрөгт, компанийн хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийг мэргэжлийн байгууллагаар үнэлүүлэн өр төлбөрөөс барагдуулж тооцох үүрэг бүхий Ажлын хэсгийг хавсралтаар байгуулсугай.

2.Тус компанийн хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийг мэргэжлийн байгууллагаар үнэлүүлэхэд шаардагдах үнэлгээний зардлыг холбогдох зардлаас шийдвэрлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Б.Энхжин)-т даалгасугай.

3.Ажлын хэсгийг удирдлага зохион байгуулалтаар ханган, үр дүнг танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч (В.Оюумаа)-д даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

PC L XL error
Error:
Operator:
Position:
ReadImage
39
IllegalOperatorSequence

1110200045

Нийслэлийн Засаг даргын 2025-оны
01 дүгээр сарын 09-ны өдрийн
А/12 дугаар захирамжийн
хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дарга.

Гишүүд:

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хяналт, үнэлгээний газрын дарга;

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Эрх зүйн бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга;

Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга;

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Дэд бүтэц, хөгжлийн бодлогын хэлтсийн дарга;

Нийслэлийн Нийтийн тээврийн бодлогын газрын Бүртгэл, техник технологийн хэлтсийн дарга;

Хот байгуулалт, хотын стандартын газрын Хотын стандарт, хөгжлийн хэлтсийн дарга;

Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны Кадастрын хэлтсийн дарга;

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтсийн дарга;

Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын Налайх дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн дарга;

Нийслэлийн Татварын газрын Төсвийн орлого, удирдлагын хэлтсийн дарга.

Нарийн бичгийн дарга:

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Өмчийн хяналт шалгалтын хэлтсийн дарга.